



ҮНДЭСНИЙ ТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛИЙН БАГШ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛД ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ БИЧИХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Тус сургуулийн “Эрдэм шинжилгээний хурлын” эмхэтгэлийн зорилго нь онол, практикийн ач холбогдол бүхий судалгааны ажил, шинэлэг үзэл санааг хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, харилцан санал бодлоо солилцох, багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөхүүлэн дэмжих, гадаад, дотоодын байгууллага хүмүүст судалгаа, шинжилгээний ажлыг сурталчилахад оршино.
2. Үндэсний техникийн их сургуулийн нийт багш нар, зөвлөх профессорууд, оюутан судлаачдын эрдэм, шинжилгээ, судалгааны бүтээлийг хэвлэнэ

Хоёр. Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд тавигдах шаардлага

1. Судалгааны ажилд тавигдах ерөнхий шаардлага:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй, тодорхой аргачлалтай байх
- Шинэлэг санаа дэвшүүлсэн байх
- Асуудал дэвшүүлж, тодорхой хэмжээнд шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байх

2. Эрдэм шинжилгээний бүтээл нь дараах бүтэцтэй байна

- Бүтээлийн нэр
- Зохиогчийн нэр, хаяг, электрон шуудангийн хаяг
- Товч хураангуй
- Түлхүүр үг
- Оршил
- Үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Зөвлөмж
- Номзүйн жагсаалт
- Хавсралт
- Зохиогчийн тухай

3. Бичвэрт тавигдах шаардлага:

- Бүтээл нь A4 хэмжээтэй, бичвэрийн үсгийн фонт Times New Roman, 12pt үсгийн хэмжээтэй, мөр хоорондын зай 1, баруун зүүн талаасаа зэрэгцсэн байна. Өгүүллийг A4 хэмжээний цаасан дээр хуудасны дээд, доод талаас 3 см; баруун, зүүн талаас 2,5 см зайг үлдээж бичнэ. Өгүүллийг бичихдээ header, footer, командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаарыг тавихгүй.
- Бичвэр дунд мөр хооронд жагсаалтыг тэмдэглэхдээ (Paragraph-Bullets) зураасан тэмдэг (-)-ийг сонгоно.
- Түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоон дээр байна.

- Зураг, хүснэгт нь бүгд дугаартай, нэртэй байх ба дугаар, нэр хоёр нь 10pt үсгийн хэмжээтэй хуудсын зүүн талд байрласан байна. Фото зураг нь JPEG өргөтгөлтэй байна. Эрдэм шинжилгээний бүтээлд авсан эшлэлийн эх үүсвэрүүдийг бүтээл дотор болон ном зүйн жагсаалтад бичнэ.
- Бүтээл нь хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, зөвлөмж, номзүйн жагсаалтыг оролцуулан 8-12 хуудсанд багтсан байна
- Бүтээлийн эшлэлийг ҮТИС-ийн эшлэл авах стандартын дагуу буюу АРА загварыг удирдлага болгон хийнэ.

4. Хүснэгтэн мэдээллийн формат

- Хүснэгтэн мэдээллийн доор нь эх сурвалжийг зайлшгүй бичих шаардлагатай. Эх сурвалжийг (Times New Roman, 12pt, *Italic*) форматаар бичнэ.
- Хүснэгт бүр нэртэй байх бөгөөд дугаарын ард нэрийг залгуулан бичнэ.
- Хүснэгтийг дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичих бол баганын гарчгуудыг давтана. Хэрэв гарчиг урт бол тэдгээрийг дугаарлаад дугаарыг нь тавина. Дараагийн хуудсанд үргэлжилж буй хүснэгтийн дээд хэсэгт Үргэлжлэл гэж бичээд хүснэгтий дугаарыг тавина.

5. Зурган мэдээллийн формат

- Бүдүүвч (схем), жишиг (диаграмм), хэмжээст (график), фото зураг зэргийг зураг гэсэн агуулгаар оруулан нэгдсэн дугаараар дугаарлана.
- Зурган мэдээллийн доор нь эх сурвалжийг зайлшгүй бичих шаардлагатай. Эх сурвалжийг (Times New Roman, 12pt, *Italic*) форматаар бичнэ.
- Зурган мэдээллийн нэрийг дугаарын ард залгуулан бичнэ.
- Томьёог Word-ын Equation ашиглан бичнэ.

6. Ишлэл, зүүлт

Судалгааны ажил бичих явцад ишлэл, зүүлт (бусдын бүтээлээс авч ашиглаж буй санаа, ойлголт, тайлбар, тодорхойлолтууд зэрэг болон нэмэлт тайлбар шаардлагатай үед)-ийг оновчтой зөв хэрэглэнэ. Ишлэл, зүүлт бичих хэлбэрүүдээс нэгийг сонгон судалгааны ажлын бүх хэсэгт тухайн хэлбэрийг баримталж бичнэ.

Ишлэл бичихдээ эх үүсвэрийг заавал бичнэ. Үүнд бусдын бүтээлийн үр дүн, санааг нэгтгэн тайлбарлаж байгаа бол зохиогчийн нэр болон оныг бичнэ. (Зохиогчдын нэрсийг латинаар бичнэ.)

7. Ашигласан материал

Ном

1. Зохиогчийн нэр (зохиогч, редактор, орчуулагч, байгууллага гэх мэт.)
2. Хэвлэгдсэн он
3. Бүтээлийн нэр, хэрвээ байгаа бол дэд гарчиг (*italic* хэлбэрээр)
4. Цувралын дугаар

5. Хэвлэлтийн дугаар
6. Хэвлэлийн газрын нэр
7. Хэвлэлийн газрын байршил

Өгүүллэг

1. Өгүүллэгийг зохиогчийн нэр
2. Хэвлэгдсэн он
3. Өгүүллэгийн нэр (тодорхойлох хашилтанд)
4. Сэтгүүлийн нэр (*italic* хэлбэрээр)
5. Сэтгүүлийн дугаар
6. Хэсгийн дугаар
7. Хуудасны дугаар

Гурав. Эмхэтгэлийн хуваарилалт

1. Эмхэтгэлийн дугаар бүрээс ҮТИС-ийн 1.2-р байрны номын санд 5, 5 хувь, ҮТИС-ийн Эрдэм шинжилгээний номын санд 5 хувь, ҮТИС-ийн бүрэлдэхүүн сургууль тус бүрд 1 хувийг албан ёсоор хүлээлгэн өгч байна.

Дөрөв. Бусад

1. Тус эмхэтгэлд тавигдах өгүүллийн чанарыг сайжруулах зорилгоор хөндлөнгийн шүүмж хийлгэнэ.
2. Эрдмийн зөвлөл нь шаардлага хангаагүй өгүүллийг буцаах, зохих хэмжээнд хүртэл товчлох эрхийг эдлэнэ.
3. Дээр дурдсан бүх шаардлагыг хангаж зарласан хугацаанд өгсөн хугацааг ирүүлсэн хугацаа гэж тооцно. Хугацаандаа ирүүлээгүй материалыг буцаана.
4. Уг эмхэтгэлд хэвлэгдсэн материалыг ҮТИС-ийн ЭЗ-ийн даргын зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, олшруулан тараахыг хориглоно. Эмхэтгэлийн зохиогчийн эрх нь ЭЗ-д хадгалагдана..
5. Зохиогч бүр нь эрдэм шинжилгээ, судалгааны ажил туурвихдаа бусад зохиогчийн эрхийн бүтээлийг хуулбарлан зөрчил буюу plagiarism гаргахгүй байх үүрэгтэй. Зохиогчийн эрхийн зөрчил нь бусдын санаа, бичвэр, хэл хэллэг зэргийг зохиогчийн нэрийг дурдалгүйгээр санаатай буюу санамсаргүй байдлаар зөрчих үйлдэл юм.
6. ҮТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд нь ЭЗ-тай зөвшилцсөний үндсэн дээр “Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл”-ийн тусгай дугаарыг эмхтгэн гаргаж болно. Энэ тохиолдолд энэхүү зааврыг удирдлага болгох бөгөөд дугаар тус бүрээс 5 хувийг ЭЗ-д хүлээлгэн өгнө.

Жишээ:

Өгүүллийн нэр

А.Зохиогч,

ҮТИС, Сургууль, Профессорын багийн нэр

Б.Зохиогч

Улс, байгууллага, албан газрын нэр

e-mail: xxxx@yuyu.zz

Хураангуй

Өгүүлэл бүрийн өмнө хураангуй бичигдэнэ. Хураангуйг Times New Roman фонд дээр 10 pt үсгийн өндөртэйгээр *Italic* хэлбэрээр бичнэ. Хураангуй нь 15 мөр, 200 үгэнд багтсан байх ёстой.

Зүйл нь шинэ мөрнөөс, мөрний эхнээс эхлэх ба мөрүүд хоорондоо 1sp зайтай байна. Мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.

Түлхүүр үг: Түлхүүр үг нь Times New Roman фонд дээр 10 pt үсгийн өндөртэйгээр Regular хэлбэрээр бичигдэнэ. Өгүүлэлд 4-5 түлхүүр үг хэрэглэнэ. Түлхүүр үг нь нэр үг, ганц тоон дээр бичигдэнэ. Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй.

Оршил

Өгүүллийн оршил хэсэгт авч үзэж байгаа асуудлын мөн чанар, урьд өмнөх судалгааны түвшин, гол онцлогуудыг бичнэ.

1. Бүлгийн гарчиг

Өгүүллийг зөвхөн Windows XP/Windows VISTA-ийн Microsoft Office 2003 программ дээр *.doc буюу *.rtf өргөтгөлтэй форматыг ашиглан Times New Roman Mon фонд дээр 10 pt үсгийн өндрийг сонгон бичнэ.

1.1 Дэд бүлгийн гарчиг

Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаарыг тавихгүй.

1.2 Дэд бүлгийн гарчиг

Зүйл нь шинэ мөрнөөс, мөрний эхнээс эхлэх ба мөрүүд хоорондоо 1sp зайтай байна. Мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.

2. Бүлгийн гарчиг

Хүснэгт нь өгүүлэлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгтийн гарчиг нь Times New Roman Mon фонддээр *Italic* хэлбэрээр 10 pt үсгийн өндөртэйгээр мөр голлон бичигдэнэ.